

ШАРГА СУМД 6-Р САРД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2017.07.03

БАГУУДЫН ИНХ БОЛОВ

5 сарын 29-нд Баянгол багийн ИНХ, 5 сарын 30-нд Сондуулт багийн ИНХ, 5 сарын 31-нд Улаантуг багийн ИНХ, 6 сарын 15-нд Хамтын хүч багийн ИНХ боллоо. Багуудын ИНХ-аар 2018 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний санал авах, эрэмбэлэх ажлыг хийлээ. Энэ үеэр ЗДТГ-ын байцаагч мэргэжилтнүүд очиж мэдээлэл хийж төлбөр хураамжаа авлаа.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨСЛИЙН СУРГАЛТ БОЛЛОО

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 3 жилийн хугацаатай сумд хэрэгжиж байгаа гамшгийн эрсдлээс хамгаалах, чадавжуулах төслийн сургалтыг 5 сарын 29-ны өдөр малчид иргэдэд зохион байгууллаа. Сургалтанд 50 гаруй малчид оролцлоо.

ЭХ ҮРСИЙН ЭЛБЭРЭЛ ТОГЛОЛТ БОЛЛОО

Сумын эмэгтэйчүүийн зөвлөлөөс санаачлан эх үрсийн баярыг тохиолдуулан “Эх үрсийн элбэрэл” урлагийн тоглолтыг хийлээ. Тоглолтонд сургууль, цэцэрлэгийн хүүхдийн төлөөлөл, байгууллага, ААН бүрийн эмэгтэйчүүдийн төлөөлөл, ахмад гэх мэт салбар бүрийн эмэгтэйчүүдийн төлөөлөл оролцсон ба тоглолтын орлогоос 1 ахмад ээжид сарын хүнсний хэрэглээ, хүнд нөхцөлд амьдарч байгаа 3 хүүхдэд баярын бэлгийг гардууллаа.

ХДХВ, ДОХ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ БОЛЛОО

Шарга сумын ЭМТ, Улаанбаатар хотын ДОХСТҮТөвтэй хамтран ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх сургалтыг 40 иргэн, дунд сургуулийн 12-р ангийн 16 сурагч нийт 56 хүнд зохион байгууллаа.

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ БОЛЛОО

Техникийн хяналтын улсын үзлэг 6 сарын 11-12-ны өдрүүдэд болж 350 машин үзлэгт орохоос 251 машин орж үзлэгийн хамралт 71.7 хувьтай байна.

СУМЫН ИТХ БОЛЛОО

Сумын ИТХ-ын ээлжит V хуралдаан энэ сарын 14-ний өдөр боллоо. Хуралдаанаар:

1. 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийн тодотгол
2. Сумын баяр наадмын журмын хэрэгжилт
3. Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай
4. ИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
5. ИТХ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт гэсэн асуудлуудыг хэлэлцлээ.

ЗДТГ-ЫН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2017 оны 6 сарын 29-30-ны өдрүүдэд Сондуулт Хамтын хүч багуудад ЗДТГ-ын нээлттэй өдөрлөгийг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж 120 гаруй малчинд 8 хууль тогтоомжийг сурталчилж мэдээлэл хийлээ.



Нээлттэй хаалганы үйл ажиллагааны үеэр ЗДТГ-ын танилцуулга, болон мэргэжилтэн бүр өөрийн хариуцсан ажил, шинэчлэн батлагдсан хууль тогтоомж, хийж хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар электрон хичээл бэлтгэж иргэдэд мэдээлэл хийлээ.



Багуудад ЗДТГ-ын даргаар ахлуулсан 16 хүний бүрэлдэхүүнтэй төрийн үйлчилгээ, урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх баг ажиллаж төрийн үйлчилгээг үзүүллээ.

Мэдээ бэлтгэсэн: Д.Ончимэг